

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 01 дүгээр сарын 07

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Нийтийг хамарсан баярын арга хэмжээний үеийн хэв журмыг сахиулах, бэлэн байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.				
1	Нийслэлийн Цагдаагийн Удирдах газрын дэд бөгөөд нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 306/4677 дугаар ажил үүргийн хуваарийн дагуу “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жилийн ой”, “Улаанбаатарын мөнгөн үдэш”, Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулагдсан “Мөнгөн өвөл 2024” арга хэмжээнүүд зохион байгуулагдах үеийн эргүүл, хамгаалалтыг зохион байгуулж ажилласан. 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Мөнгөн өвөл 2024” арга хэмжээний үеийн хэв журмын хамгаалалтын үед 2 алба хаагч, 1 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж, үүсэж болзошгүй гэмт хэрэг зөрчлийг баримтжуулах энгэрийн камер, хамгаалалтын үед ашиглагдах радио станцын сувагт холбооны инженер үзлэг шалгалтыг хийж, үүрэг гүйцэтгэж буй албан хаагч нартай дотоодын сувгаар мэдээ мэдээлэл солилцон бэлэн байдлыг хангуулж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 08:00-09:00 цагийн хооронд зохион байгуулагдсан “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жилийн ой”-д зориулан Монгол Улсын Төрийн далбааг мандуулж, Төрийн дуулал эгшиглүүлэх үеийн арга хэмжээний үед 4 чиглэлд 8 алба хаагч, 1 тээврийн хэрэгсэлтэйгээр хяналт тавиж үүрэг гүйцэтгэсэн.			100
Үүрэг, даалгавар ТАВ: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхдүүдийг гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах.				
2	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 1 дүгээр улирлын амралт эхэлсэнтэй холбогдуулан иргэд, олон нийт болон дүүргийн Ерөнхий боловсролын 20 сургуулиудад заавар, зөвлөмжийг хүргүүлсэн.		Дүүргийн Цагдаагийн газартай хамтран хүүхдийг гэнэтийн осол гэмтлээс	70

	Хүүхдийг ахуйн осол гэмтэл, өндрөөс унаж бэртэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 зөвлөмж, шинэ жилийн баяр, олон нийтийн арга хэмжээнд хүүхдийг бэртэж гэмтэх, төөрөх, даарч осгохоос сэргийлэх тухай 3 төрлийн зөвлөмж, зурагт хуудсыг бэлтгэн хүргүүлж, цахим хуудаст байршуулан ажилласан. Мөн Нийслэлийн шинэ жилийн баярын арга хэмжээн дээр хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1 төөрсөн хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэж, 163 эцэг эхэд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Агаар салхинд гарахдаа хүүхдийн аюулгүй байдлыг (цана, чаргаар гулгах, автомашинаар чирэх) хангах талаарх 2 төрлийн сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас, зөвлөмжийг цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтэд түгээн ажилласан.		урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.	
Үүрэг, даалгавар ЗУРГАА: 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл эргүүл, жижүүр томилон ажиллуулж, инженер хангамжийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, шуурхай бэлэн байдлыг хангаж ажиллах.				
3	Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн Удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв-7 хариуцлагатай жижүүрийн батлагдсан хуваарийн дагуу дүүргийн орон сууцны 1-6 дугаар хороодын орон сууцуудын инженерийн шугам сүлжээний хэвийн үйл ажиллагаа, шуурхай бэлэн байдлыг ханган ажилласан. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ний Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн даргын “Найдвартай ажиллагааг хангаж ажиллах тухай” А/19 дүгээр тушаалаар хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд цахилгаан эрчим хүчээр хэвийн хангаж, шуурхай бэлэн байдлыг ханган ажилласан.			100
Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: 2025 онд барих Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн талаар Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах.				
4	Дүүргийн 17 дугаар хороо, 960 суудалтай, спорт заалтай, сургуулийн барилга, гүйцэтгэгч “Содон номин констракшн”, газар чөлөөлөх 45 нэгж талбараас 24 нэгж талбар чөлөөлсөн. Дүүргийн 13 дугаар хороо, 150 ортой тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, гүйцэтгэгч “Голден дрийм” ХХК, газар чөлөөлөх 22 айлаас 21 айл чөлөөлсөн. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсээс үлдсэн 1 айлтай аман байдлаар газар чөлөөлөх тохиролцоонд хүрсэн. Барилгын ажил 2025 оны 03 сараас эхлэхээр хүлээгдэж байна. Дүүргийн 23 дугаар хороо, 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, газар чөлөөлөх 9 айлаас 8 айл газраа чөлөөлсөн, 1 айлтай тохиролцоонд хүрээгүй тул тухайн айлыг хасаж барилгын ажил явуулахаар шийдвэрлэсэн. Одоогоор гүйцэтгэгч байгууллага шалгараагүй байна. Дүүргийн 19 дүгээр хороо, 240 суудалтай, бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, барилгын ажлын гүйцэтгэл 85%-тай, барилгын ажлыг хүлээлгэн өгөх гэрээний		Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	70

	хугацаа 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр байсан боловч ажлын явц удаашран 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гэрээг сунгасан. Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалан зогссон тул 2024 оны 01/1765 дугаартай албан шаардлага хүргүүлэн гүйцэтгэгч “Саран инж девелопмент” ХХК-ний гэрээг цуцлах шийдвэр гаргасан. Дүүргийн 16 дугаар хороо, 100 ортой цэцэрлэгийн барилга, барилгын ажлын явц 80%-тай, барилга угсралтын ажил дуусаж гадна тохижилт, гадна фасад, дотор заслын ажлыг 2025 онд дуусган ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Дүүргийн 6 дугаар хороо, 108 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, 240 ортой барилгыг шинээр барихаар хуучин барилгыг буулгаж, суурь болон 2 давхар хүртэл төмөр бетон, каркас угсралтын ажил хийгдсэн. Дүүргийн 12 дугаар хороо, Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлын гүйцэтгэл 94%-тай байгаа бөгөөд 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын комисс ажиллаж барилгын ажил удаашралтай байгаа тул гүйцэтгэгч компанийн гэрээг цуцалсан. Нийслэлийн Засаг даргын 547 дугаар захирамжаар 218 сая төгрөгтэй үлдсэн ажлын эрх шилжин ирж, “Хүрэл соёмбо” ХХК шалгаран барилгыг 2025 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.			
Үүрэг, даалгавар АРВАН ЕС: 2025 оны 01 дүгээр сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсыг шинэчлэх, байгууллагуудын мэдээллийг урсгалыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийж, танилцуулах.				
5	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын www.chingeltei.gov.mn албан ёсны цахим хуудсыг орчин үеийн загвартай, ашиглахад ойлгомжтой болгох зорилгоор “Мэжик глобал медиа” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ хийж, цахим хуудсыг шинэчлэх ажлыг гүйцэтгүүлж байна. Дүүргийн цахим хуудас шинэчлэх ажлын гэрээнд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр дуусгахаар хамтран ажиллаж байна.		Үүрэг, даалгаврын хэрэгжилт хангагдана.	70
Үнэлгээний дундаж			82.0%	

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ЛХАГВАСҮРЭН

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ